

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 23/06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 60 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Бодь даатгал ХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.5, 8.12.6, 8.12.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 06-ны өдрийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ** нь:

1. Бодь даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал/ гэх/-ыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 03 сарын 07-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2023 оны 03 сарын 09-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа 2023 оны 03 сарын 09-ний өдрийн дотор мэдээлсүгэй.
4. Мэдээллийн давталтыг 2023 оны 03 сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан дахин зарласугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 03 сарын 13-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал Б.Золбаяр,

Гишүүд: Санхүү, эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Алтанзул, Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар, ТУЗ-н Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Маркетингийн ахлах менежер Г.Нарантуяа, Хуульч Б.Мэндсайхан, Менежер Б.Онон, Нягтлан бодогч Г.Дуламсүрэн, Б.Баяр

2023 оны 03-р сарын 06 өдөр
Дугаар.....25/06

8. Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан этгээдээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагад ирүүлсэн санал байхгүй болохыг дурдсугай.
9. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
10. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
11. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
12. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
13. Хурлын материалыг 2023 оны 03 сарын 13-ны өдөр брокер, диллерын компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийнхооронд ирж танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
14. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Би Ди Сек ҮЦК ХХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2023 оны 04 сарын 24-ний өдрийн 15:00 цаг байна.
15. Хурлын даргаар Бодь даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Золбаярыг томилсугай.
16. Хурлын тооллогын комиссын даргаар Хуульч Б.Мэндсайхан, гишүүд: Б.Баяр, Г.Дуламсүрэн болон Би Ди Сек ҮЦК ХК-ийн ажилтан Б.Онон нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
17. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга Б.Золбаяр болон Хурал зохион байгуулах комиссын гишүүн Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар нарт даалгасугай.
18. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ